210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,650,300.00	38,027,678.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,487,000.00	3,475,150.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,571,600.00</b>	<b>17,565,800.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,571,600.00</b>	<b>17,565,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,411,100.00	14,411,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,160,500.00	3,154,700.00

**Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>164,266,100.00</b>	<b>114,419,439.00</b>
220001	Барилга байгууламж	87,510,700.00	75,494,681.00
221001	Их засвар	25,755,400.00	8,299,958.00
222001	Тоног төхөөрөмж	51,000,000.00	30,624,800.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>101,000,000.00</b>	<b>99,797,500.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	101,000,000.00	99,797,500.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,960,401,000.00</b>	<b>1,843,778,384.73</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,161,165,200.00</b>	<b>1,120,993,253.63</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,041,923,900.00	1,001,751,953.63
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	119,241,300.00	119,241,300.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>605,886,800.00</b>	<b>582,303,644.60</b>
320001	Орон нутгийн төсвөөс	605,886,800.00	582,303,644.60
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>16,644,600.00</b>	<b>8,093,310.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,644,600.00	8,093,310.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>176,704,400.00</b>	<b>132,388,176.50</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,000,000.00	132,387,976.50
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	200
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	75,704,400.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	115,256,772.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	156,784,336.41
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>740</b>	<b>740</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>9</b>	<b>9</b>
610001	Төсвийн байгууллага	9	9
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>95</b>	<b>95</b>
620001	Удирдах ажилтан	11	11
620002	Гүйцэтгэх ажилтан	53	53
620003	Үйлчлэх ажилтан	26	26
620004	Гэрээт ажилтан	5	5
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>541</b>	<b>541</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>441</b>	<b>441</b>
630001	Төрийн өмчит ЕБС	441	441
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>100</b>	<b>100</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	100	100
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>95</b>	<b>95</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	28	28
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	5
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	14	14
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32	32
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

**Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,409,806.27	135,034,440.27
2	УРСГАЛ ЗАРДАЛ	95,409,806.27	135,034,440.27
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,699,277.00	75,389,912.63
4	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	4,536,553.00
5	Цэвэр, бохир ус	-	4,536,553.00
6	Хангамж, бараа материалын зардал	899,780.00	109,569.00
7	Бичиг хэрэг	-	109,569.00
8	Тээвэр шатахуун	899,780.00	-
9	Норматив зардал	1,667.82	-
10	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,667.82	-
11	Эд хогшил, урсгал засварын зардал	480,000.00	-
12	Багаж техник хэрэгсэл	80,000.00	-
13	Урсгал засвар	400,000.00	-
14	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,936.73	625,306.00
15	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,936.73	625,306.00
16	Бараа үйлчилгээний бусад зардал	48,714,944.00	70,118,484.63
17	Бараа үйлчилгээний бусад зардал	48,714,944.00	64,779,284.63
18	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,339,200.00
19	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,710,529.27	59,644,527.64
20	Бусад урсгал шилжүүлэг	20,434.80	48,557,800.00
21	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	27,401,600.00
22	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,434.80	7,965,800.00
23	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	13,190,400.00
24	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,275,729.27	11,086,727.64
25	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	12,274,259.27	11,086,727.64
26	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,470.00	
27	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	95,409,806.27	135,034,440.27
28	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,409,806.27	135,034,440.27
29	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,052,975.90	75,812,109.00
30	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,356,830.37	59,222,331.27
31	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татварын орлогын болон мэдээ тайлан гаргалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Д.Даваа-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Т.Майцэцэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 05/91 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, зөв бодлого, оновчтой шийдэл, тогтвортой хөгжлийг ханган иргэд үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамж, стандартын шаардлагад нийцсэн нийгэм эдийн засгийн эрчимтэй өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Баянжаргалан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Сумын санхүүгийн албанаас мөнгөн хөрөнгө, бараа материал, төсвийн зардалд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар төлөвлөсөн ажлыг хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт, аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид эрсдэлд суурилсан дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянжаргалан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн нийт орлого 2,881,474.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 43,222.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 32,416.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,881,474.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 43,222.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувиар буюу 32,416.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

#### **Орлогын талаар:**

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн татварын болон татварын бус орлого 107,386.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилт 584,974.6 мянган төгрөг, аймгаас санхүүгийн дэмжлэг 506,715.7 мянган

төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 119,241.3 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 1,080,901.9 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 8,093.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 135,034.4 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 132,388.0 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн борлуулалтын орлого 59,276.0 мянган төгрөг, БНСБС-д 1,100.0 мянган төгрөг, ОНХО нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн орлого 11,086.7 мянган төгрөг нийт 2,707,220.6 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.

Баянжаргалан сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 55,950.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 61,221.1 мянган төгрөг, нийт 117,171.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 105,569.8 мянган төгрөг, татварын бус орлого 1,816.5 мянган төгрөг, нийт 107,386.3 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 9,784.8 мянган төгрөгөөр дутуу буюу 91,6 хувиар биелүүлсэн байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 16,543.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 121,310.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 137,854.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба тайлант онд 102,376.0 мянган төгрөгийн хөрөнгө актлагдаж хасагдсан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 217,445.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 205,296.2 мянган төгрөг, нийт 422,742.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 385,774.4 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

***Авлага, өглөгийн талаар:***

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 35,415.6 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 198,610.1 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 1,193.9 мянган төгрөг нийт 235,219.6 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 196,740.2 мянган төгрөг буюу 83,6 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 29,136.9 мянган төгрөг буюу 12,4 хувийг ЭМТ, 6,078.7 мянган төгрөг буюу 2,6 хувийг Эргэлтийн эмийн сангийн авлага эзэлж байна.

Байгууллагад төлөх 5,013.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 19,571.6 мянган төгрөг, нийт 24,584.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Нийт өрийн 12,768.6 мянган төгрөг буюу 51,9 хувийг ОНХС, 5,013.1 мянган төгрөг буюу 20,4 хувийг сургууль, 3,650.0 мянган төгрөг буюу 14,8 хувийг БНСБС, 3,153.0 мянган төгрөг буюу 12,8 хувийг ЭМТ-ийн өр эзэлж байна.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 238,324.1 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 4,767.9 мянган төгрөг, нийт 243,091.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 225,158,8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,015,723.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөг/

**Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	170,502,724.3	243,092,043.4	72,589,319.1
Авлага	215,523,270.0	235,219,697.2	19,696,427.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	188,191,088.5	225,158,806.28	36,967,717.8
Нөөцийн бараа /сурах бичиг/		-	-
Үндсэн хөрөнгө	3,101,156,565.0	3,015,723,570.8	(85,432,994.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,675,373,647.9</b>	<b>3,719,194,117.7</b>	<b>43,820,469.9</b>
Өр төлбөр	48,482,528.0	24,584,710.4	(23,897,817.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,626,891,119.9	3,694,609,407.4	67,718,287.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,675,373,647.9</b>	<b>3,719,194,117.7</b>	<b>43,820,469.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 225,158.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 36,967.7 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш шатах тослох материал, хүнсний материал, мал амьтад, бусад хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,015,0723.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 85,433.0 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө актлагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,694,609.4 мянган төгрөг болж 67,718.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,914,897.1 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Баянжаргалан сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 9 дүгээр тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 117,485.9 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 1,814,897.1 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,832,132.7 мянган төгрөгөөр тодотгон баталсан ба сум хөгжүүлэх сангийн орлогыг 101,000.0 мянган төгрөгөөр, нийт 1,933,132.7 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 18,235.6 мянган төгрөгөөр нэмж санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 7 хөтөлбөр 20 арга хэмжээнд зориулан нийт 1,933,132.7 мянган төгрөг төлөвлөсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлагдсан төлөвлөгөөг нийт 1,960,401.0 мянган төгрөгөөр тайлагнасан нь ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс 27,268.3 төгрөгөөр дутуу зөрүүтэй байна.

Нийт зардлын 1,041,923.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 681,591.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 16,644.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 119,241.3 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 101,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 1,588,033.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 114,419.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 99,797.5 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,802,250.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 40,313.5 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 1,335.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,802,250.8 мянган төгрөг буюу 91,9 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 135,034.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 75,389.9 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 48,557.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 11,086.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Баянжаргалан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, БНСБС-ийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-т 1 зөвлөмж, ИТХ-д 2 зөвлөмж, Соёлын төвд 1 зөвлөмж, СХС 24,719.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 36.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Уваа-Уул аудит ХХК аудит хийж, ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, эргэлтийн эмийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 4,773.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 5,013.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 10,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,719.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 3 зөвлөмж, Эргэлтийн эмийн санд 28,256.7 мянган төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Баянжаргалан сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор тодотгон баталсан 1,933,132.7 мянган төгрөгийн төсвийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд 27,268.3 мянган төгрөгөөр буюу ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс тусгай зориулалтын шилжүүлэг 27,268.3 мянган төгрөг зөрүүтэй байгаа зөрчлийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулах шаардлагатай байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон мэдээлэл 22 байна. Шилэн дансны мэдээлэлд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тайлбарлаагүй, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй, аудитын тайланг байршуулаагүй зэрэг зөрчил илэрсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтээс СХС-ийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад ковидын зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,784.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,784.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад тайлан залруулагдаагүй болно.

#### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

#### 4.3 Албан шаардлага

Төв аймгийн Баянжаргалан сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Зээлийн авлагын судалгаагаар 31 иргэнтэй холбоотой 178,186.1 мянган төгрөгийн авлагатай үүнээс 1 иргэнтэй холбоотой 7,279.5 мянган төгрөгийн авлага шүүхэд шилжүүлсэн ба 3 иргэнтэй холбоотой 24,719.2 мянган төгрөгийн зээлийн авлага

хугацаа хэтэрсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана”, 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой**

###### **1.1. Илрүүлэлт:**

Сумын төсөвт төвлөрүүлэх орлого нийт дүнгээрээ 9,784.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг нэр төрөл бүрээр жигд ханган биелүүлэхэд онцгой анхаарч ажиллах

##### **2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой**

###### **2.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны цахим хуудасны мэдээлэлд тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон мэдээлэл 22 мэдээлэлтэй, мөн төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тайлбарлаагүй, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй, аудитын тайланг байршуулаагүй зэрэг зөрчил илэрсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, ойлгомжтой хугацаанд нь оруулах, төсвийн төсөл болон төсвийн гүйцэтгэлийн хэмнэлтийн тайлбар шалтгааныг ойлгомжтой мэдээлж хэвших

**Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа,		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Аудитын дүгнэлт
1	Баянжаргалан сумын Засаг дарга	1	9,784.8							1	9,784.8	Зөрчилгүй
<b>ТТЗ-ийн дүн</b>		<b>1</b>	<b>9,784.8</b>	-	-	-	-	-	-	<b>1</b>	<b>9,784.8</b>	
2	Баянжаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	-	-	-	-	-	-	-	2	-	
3	Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	-	-	-	-	1	-	Зөрчилгүй
4	Баянжаргалан сумын Соёлын төв	1	-	-	-	-	-	-	-	1	-	
5	Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль	5	9,786.5	-	-	-	-	1	4,773.5	4	-	Зөрчилгүй
6	Баянжаргалан сумын хүүхдийн цэцэрлэг	3	14,719.0	-	-	-	-	1	10,000.00	2	4,719.0	Зөрчилгүй
7	Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төв	3	-	-	-	-	-	-	-	3	-	Зөрчилгүй
<b>ТШЗ-ийн дүн</b>		<b>15</b>	<b>24,505.5</b>	-	-	-	-	<b>2</b>	<b>14,773.5</b>	<b>13</b>	<b>4,719.0</b>	
8	Баянжаргалан сумын Сум хөгжүүлэх сан	2	24,755.6	-	-	-	-	1	24,719.2	1	36.4	
9	Баянжаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	
10	Баянжаргалан сумын Эмийн эргэлтийн сан	6	28,256.70	-	-	-	-	-	-	6	28,256.70	
<b>ОНТС-ийн дүн</b>		<b>8</b>	<b>53,012.3</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>24,719.2</b>	<b>7</b>	<b>28,293.1</b>	
<b>Нийт дүн</b>		<b>24</b>	<b>87,302.6</b>	-	-	-	-	<b>3</b>	<b>39,492.7</b>	<b>21</b>	<b>42,796.9</b>	